



## **“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 07 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар ТУЗ2020-03/05

Улаанбаатар  
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан худалдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.3, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.7, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, дах хэсэг, 8-р зүйлийн 8.8.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 09-р сарын 14-ний өдрийн Даваа гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Таван Богд Групп”-ийн төв байрны, 2,5-р давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

Үүнд:

2.1 Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус шинэ гишүүдийг томилох,

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй компанийн үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр /Утас: 94990778, [jdf-operations@tavanbogd.com/](mailto:jdf-operations@tavanbogd.com/), ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ /Утас: 95958708, [Baterdene.b@tavanbogd.com/](mailto:Baterdene.b@tavanbogd.com/) нартай холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байхаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 17:00 цаг хүртэл тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар ТУЗ-ын гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын даргаар Т.Солонго, гишүүнээр Г.Болорцэцэг, нарыг тус тус томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Д.Ганбатыг, гишүүдээр үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр, няглан бодогч Д.Сарангуга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ нарыг тус тус томилон, хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрсүгэй.

12. Хувьцаа эзэмшигчдийг ээлжит бус хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс Гүйцэтгэх захирал Ё.Ганбат, үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН

2020 оны 07-р сарын 31-ний өдрийн ТУЗ-ийн  
Хурлын ТУЗ2020-03/05 тогтоолын хавсралт №2

**Өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгөх  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар**



**"ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ" ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

"ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Даваа гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байрны 2,5-р давхарт байрлах хурлын танхимд болно.

**Хурлаар хэлэлцэх асуудал**

- ✓ Компанийн ТУЗ-ийн өрдийн болон хараат бус шинэ гишүүдийг томилох,

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 08-р сарын 21-ний өдөр байна.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй Брокер дилерийн компаниуд болон компанийн байранд 2020 оны 8-р сарын 10-ны өдрөөс ирж танилцаж боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн байр. Ажлын 1, 3, 5 дахь өдрийн 08.00-17.00 цагийн хооронд

Утас: 95958708, 94990778 утсаар холбогдоно уу.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**